

rainbow
AQUAMATE[®]




Үйлчиллүүлэгчийн Тусламжийн Дугаар

РэксЭйр-ийн (Rexair) Үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх хөтөлбөрийн хувьд РэйнЖет (RainJet) тус бүр нь чанарын хяналтын туршилтыг давсны дараа Үйлчлүүлэгчид үзүүлэх дэмжлэгийн цуврал дугаарыг авна. Энэ цуврал дугаар нь дараах боломжийг танд олгоно:

- ✓ Танд зориулсан эзэмшигчийн хувийн дугаар
- ✓ Таны Нийлүүлэгчид зориулсан баталгааг тодорхойлох дугаар
- ✓ Чанарын Хяналын Баталгааны туршилтад тэнцсэн баталгаа
- ✓ "Үйлдвэрийн шинэ" нөхцөлийн баталгаа

Шинэ РэйнЖет нь энэ дугааргүйгээр худалдагдсан бол жинхэнэ биш юм. Хэрэв цувралын дугаар нь байхгүй бол РэксЭйр нь гарал үүсэл, эдэлгээ эсвэл нөхцөл байдлын талаар заргыг хүлээн авахгүй. Хэрэв өөрийн AquaMate дээр цувралын дугаарыг байршуулах боломжгүй бол РэксЭйр-ийн үйлчлүүлэгчийн үйлчилгээний газартай холбоо барихыг хүсье.

АКУАМЭЙТ-ИЙН ЦУВРАЛЫН ДУГААР



ТАНЫ АЛБАН ЁСНЫ RAINBOW НИЙЛҮҮЛЭГЧ

НЭР		 Та өөрийн АкуАмэйтийн арчилгаа, баталгаа, засвар, сэлбэг болон бусад үйлчилгээний талаар ойролцоох Баталгаат Нийлүүлэгчтэй холбогдоно уу.
ХАЯГ		
ХОТ/МУЖ/ ШУУДАН		
УТАС		
Э-МЭЙЛ		

Rexair LLC

50 W. Big Beaver Road, Suite 350 | Troy, Michigan 48084 | USA
(248) 643-7222 | custserv@rexairllc.com | rainbowsystem.com

© 2019 Rexair LLC, all rights reserved. Rainbow®, RainbowMate®, MiniJet®, JetPad®, RainMate®, RainJet®, AquaMate®, Rexair®, The Power of Water®, Wet Dust Can't Fly® and the configuration of the Rainbow® Clearing System are registered trademarks of Rexair LLC, Troy, Michigan, United States.

Аюулгүй ажиллагааны чухал заавар



УГ ТЭМДЭГЛЭГЭЭ НЬ 'АНХААРУУЛГА' ГЭСЭН УТГАТАЙ.
Цахилгаан хэрэгсэл ашиглах бүрт дараах үндсэн арга хэмжээг заавал авна. Үүнд:



УГ ТЭМДЭГЛЭГЭЭ НЬ 'ЭНЭ ТӨХӨӨРӨМЖИЙГ' АЖИЛЛУУЛАХЫН ӨМНӨ ЗААВРЫГ БҮРЭН УНШИНА УУ' ГЭСЭН УТГАТАЙ.



УГ ТЭМДЭГЛЭГЭЭ НЬ 'ЭНЭ НЬ ХӨӨСӨРДӨГ УГААЛГЫН НУНТАГ АГУУЛАХ МАГАДЛАЛТАЙ УСАРХАГ УУСМАЛЫГ ШИНГЭЭДЭГ УУР СОРОХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ ЮМ' ГЭСЭН УТГАТАЙ.

IPX4

IPX4 нь УС НЭВЧИЛТИЙН ЭСРЭГ ХАМГААЛАЛТЫН ТҮВШИН ЮМ.

! АНХААР: ГАЛ, ЦАХИЛГААНЫ ЭРСДЭЛ, БЭРТЛИЙГ БАГАСГАХАД

1. Цахилгаанд залгасан үед төхөөрөмжийг орхихгүй байх. Ашиглахын өмнө болон ашиглаагүй үед заавал цахилгаанаас салгана.
2. Цахилгаанд цохиулах аюулаас сэргийлэхийн тулд зөвхөн дотор орчинд хэрэглэх.
3. Цахилгаанд цохиулах, гал гарах аюулаас сэргийлэхийн тулд энэ машинтай хамт хэрэглэхэд зориулсан Rainbow цэвэрлэгээний бүтээгдэхүүнийг ашиглах.
4. Цахилгаанд цохиулах аюулаас сэргийлэхийн тулд нойтон зүйл соруулах тохиргоотой Rainbow-ыг ашигла. Rainbow-ын эзэмшигчийн гарын авлагатай танилцана уу. Цахилгааны залгуурыг аливаа аргаа өөрчилж болохгүй.
5. АкуаМэйт нь цахилгаан мотор ба цахилгааныг агуулсан байдаг. Цахилгаанд цохиулах аюулаас сэргийлэхийн тулд усны савыг усаар дүүргэх эсвэл цэвэрлэхдээ цахилгааны утсыг усанд дүрж БОЛОХГҮЙ.

! ЧУХАЛ САНАМЖ

6. АкуаМэйт усны сав нь зөвхөн цэвэр, хүйтэн усаар угаах зориулалттай. АкуаМэйтийн эвдрэлээс сэргийлэхийн тулд дараах төрлийн ус шингэн хэрэглэхгүй байх шаардлагатай:
 - Халуун ус, шингэн.
 - Rainbow бүтээгдэхүүн зэрэг угаалгын нунтаг.
 - Худалдаанд байгаа цэвэрлэгээний шингэн эсвэл усмал.

7. Зөвхөн AquaMate Concentrate Solution (АкуаМэйт Концентратын Уусмал) эсвэл Clean Floor Concentrate Solution (Цэвэр Шал - Концентратын Уусмал) –ыг хажуугийн савангийн саванд хийж хэрэглэх.
8. Модон, паркетан эсвэл гантиг шалны цэвэрлэгээнд хэрэглэж болохгүй.
9. Rainbow Power Nozzle (Моторт Хошуу)-г хэрэглэхийн өмнө хивсээ сайтар хатаасан байх.
10. АкуаМэйтийн цэвэр усны сав хоосон үед асаавал хавхлаг эвдрэх аюултай тул ажиллуулж болохгүй.
11. Цаашдын аюулгүй ажиллагаанд Rainbow Эзэмшигчийн Гарын Авлагыг мөрдлөг болгох.

Давхар Тусгаарлагчтай Төхөөрөмжийн Үйлчилгээ

Давхар тусгаарлагчтай хэрэгсэлд газардуулагчийн оронд тусгаарлагчийн хоёр Давхар тусгаарлагчтай хэрэгсэлд газардуулагчийн оронд тусгаарлагчийн хоёр систем холбогдсон байна. Газардуулагчгүй гэдэг нь давхар тусгаарлагчтай тул нэмэлт газардуулагч хэрэглэх шаардлагагүй гэсэн үг. Давхар тусгаарлагчтай төхөөрөмж ашиглахад маш их анхаарал, системийн ажиллагааны талаарх мэдлэг шаардлагатай ба зөвхөн Rainbow-ын үйлчилгээний ажилтнаар хийлгэх хэрэгтэй. Давхар тусгаарлагчтай төхөөрөмжийн сэлбэгийг солиход яг ижил загварыг ашиглах шаардлагатай. Давхар тусгаарлагчтай төхөөрөмж нь “ДАВХАР ТУСГААРЛАГЧТАЙ” эсвэл “ДАВХАР ТУСГААРЛАЛ” гэсэн тодотголтой байна. Эмблем (дөрвөлжин дотор дөрвөлжин) нь мөн төхөөрөмж дээр дарагдсан байгаа. Цэвэрлэгээнээс бусад аливаа үйлчилгээ нь Rainbow-ын Баталгаат Нийлүүлэгч эсвэл үйлчилгээний төвөөр хийгдсэн байна.



**ЭДГЭЭР ЗААВРЫГ
ХАДГАЛЖ АВНА УУ**

ЭНЭХҮҮ БАРАА НЬ ЗӨВХӨН ГЭРИЙН НӨХЦӨЛД АШИГЛАХАД
ЗОРИУЛАГДСАН. AQUAMATE-Г ЗӨВХӨН RAINBOW
ЭЗЭМШИГЧИЙН ГАРЫН АВЛАГАД. ЗААСНЫ ДАГУУ “RHCS19
RAINBOW” ЗАГВАРЫН ХАМТААР ХЭРЭГЛЭХ.

Та Өөрийн AquaMate® -Тэй Танилцана Уу



— Саван + Ус
— Зөвхөн Ус
— Хандлах



1. AquaMate
2. AquaMate Усны сав
3. Зэвэрдэггүй Төмөр Хоолой*
4. Rainbow Хоолой*
5. Rainbow*
6. Rainbow Тулгуур Суурь ба Усан Сан*
7. AquaMate Хивс Цэвэрлэгч

* Хавсаргаагүй

АНХААР: АкуаМэйтийг модон, паркетан эсвэл гантйг шал, Персийн, Ази ширдэг болон бусад норгож, зурж болохгүй гадаргуугийн цэвэрлэгээнд хэрэглэж болохгүй.

Хадгалалт, Засвар

- Цэвэр хуванцар линз нь АкуаМэйтийн урд хэсэгт суурилсан ба цэвэрлэгээний хооронд авч цэвэрлэх боломжтой.
- Сойзон дамрыг доош татаж, цэвэрлэгээний хооронд авч цэвэрлэх боломжтой.
- Саваа хоолойн усыг цэвэрлэхэд урд хаалтыг салгаж, Rainbow-ыг 20 секунд ажиллуул.
- Жижиг саван их ажил гүйцэтгэнэ шүү! Хэмжигч аягаар нэг саванг савангийн саванд хийжусны савны үлдсэн хэсгийг цэвэр усаар дүүргэ.
- АкуаМэйтийг саванд нь үлдэгдэл ус эсвэл савантай байлгаж болохгүй.
- АкуаМэйтийг хадгалахын өмнө усны савны үлдэгдэл усыг шавхаж, савыг хоослох.
- Хавхлагыг ямагт "off" горимд унтрааж, усны савыг салга. Энэ нь ус асгарахаас сэргийлнэ.
- Хэрэв АкуаМэйтийг түр хугацаанд ч хамаагүй анхааралгүй орхих бол хавхлагыг ямагт "off" горимд унтрааж бай.

Шууд ажиллуулах заавар

1. Хивсээ Цэвэрлэхэд Бэлэн Болгох...

- Rainbow болон Power Nozzle хошууг нийт талбайг хир, тоосыг бүрэн соруулж цэвэрлэхэд ашигла.
- Усны савыг суллаж, цэвэр усаар зайлах. Ус дүүргэх хэрэггүй.

2. Акуамэйтийг Бэлтгэх...

- Усны саваа хоосон эхэлж, Rainbow их биеийг суурьтай холбо. Хоолойг холбох.
- Акуамэйтийн дээд хэсэг дэх нүхэнд сорогч хоолойн холбогчийг агаар сорогчид холбон, цоожлогдох дуу гартал доош дар.
- Хэмжигч аягаар нэг Rainbow Акуамэйт уусмал (AquaMate Concentrate) хэмжиж, Акуамэйтийн савангийн саванд хийх.
- Акуамэйтийн савангийн савны үлдсэн хэсгийг гоожуурын хүйтэн бүлээн, цэвэр усаар дүүргэж, тагийг сайтар таглах.
- Акуамэйтийн усны савыг гоожуурын хүйтэн бүлээн, цэвэр усаар дүүргэж, тагийг сайтар таглах.
- Акуамэйтийн усны савыг их биед суурилуулж, түгжих.

3. Шингэн Саван...



- Акуамэйтийн тохиргоог SOAP + WATER (САВАН+УС) горимд тааруулж, Rainbow-ын ажиллах хүчийг хүчтэй горимд тохируул.
- Гохыг шахаж, уусмалыг хивсэн дээр жигд тараах. Гохыг суллаж, уусмалын багаж ашиглан хойш урагш үйлдлээр шалны гадаргууг цэвэрлэнэ. Сойзны дамрыг бүтэн эргэлдүүлэхэд бариулын гохны түгжээг ашигла.

4. Зайлах...



- Акуамэйтийн тохиргоог WATER ONLY буюу ЗӨВХӨН УС гэсэн горимд тохируул.
- Гохыг шахаж, уусмалыг хивсэн дээр жигд тараах. Гохыг суллаж, уусмалын багаж ашиглан хойш урагш үйлдлээр шалны гадаргууг цэвэрлэнэ. Сойзны дамрыг бүтэн эргэлдүүлэхэд бариулын гохны түгжээг ашигла.

5. Үнэртнээр Ариутгах...



- Акуамэйтийн тохиргоог EXTRACT буюу үнэртнээр ариутгах горимд тохируул.
- Үлдсэн шингэнийг хойш зөөлөн ухрах хөдөлгөөнөөр аажим тараана.
- Хэт хуурай хивс, бүрээсэнд нийт талбайд 2 дахин уусмалаа тарааж цэвэрлэнэ.
- Цэвэрлэж дууссаны дараа усны саваа суллаж, усаар зайлж, хатаа.


AquaMate-Ийг Ажиллуулах

Акуамэйт нь тохиргоо хийх шаардлагатай байж магад ба үүнд нь ойролцоогоор 20 секунд хангалттай. Тохиргооны хугацааг багасгахад хэдхэн зүйл хийхэд хангалттай:


- Усны сав нь зөв суурилсан эсэхийг шалга.
- Хавхлагыг SOAP + WATER буюу САВАН+УС горимд шилжүүл
- Бариулын гохыг хэд хэдэн удаа атгаж, сулла.

Хэрэв Акуамэйтийг ажиллуулж байх явцад савангийн нөөцлөгч сав хоосорч, хавхлаг SOAP + WATER буюу САВАН+УС горимд байгаа бол, агаар нь савангийн нөөцлөгч саваар дамжин эргэлдэх учир ус шүршигдэхгүй. Акуамэйтийг савангүй ажиллуулж байх явцад тохиргоо алдагдуулахгүйн тулд савангийн нөөцлөгч савыг байнга усаар дүүргэж байх.


1




2




3




4




5




6




7




8




9




10




11




12




13




14



15



16





rainbowsystem.com

Rexair LLC | Troy, Michigan

© 2019 Rexair LLC | R17504AC-0